



## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

- |      |   |           |      |
|------|---|-----------|------|
| 613. | Монгол Улсын Ерөнхий аудиторыг чөлөөлөх тухай | Дугаар 45 | 2289 |
| 614. | Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох тухай  | Дугаар 46 | 2290 |

### МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- |      |   |            |      |
|------|---|------------|------|
| 615. | Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 187 | 2290 |
|------|---|------------|------|

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- |      |  |           |      |
|------|--|-----------|------|
| 616. | Улаан буудайн талаар авах зарим арга хэмжээний тухай | Дугаар 77 | 2291 |
|------|--|-----------|------|

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 10 дугаар сарын 11-ний өдөр	Дугаар 45	Улаанбаатар хот
--------------------------------------	-----------	-----------------

#### Монгол Улсын Ерөнхий аудиторыг чөлөөлөх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.8 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Чойжамцын Раднааг Монгол Улсын Ерөнхий аудиторын үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2012 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**



## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2012 оны 10 дугаар  
сарын 11-ний өдөр

Дугаар 46

Улаанбаатар  
хот

### Монгол Улсын Ерөнхий аудиторыг томилох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1, 13.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Ерөнхий аудиторроор Аюурын Зангадыг томилсугай.

2.Энэ тогтоолыг 2012 оны 10 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**З.ЭНХБОЛД**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2012 оны 10 дугаар  
сарын 16-ны өдөр

Дугаар 187

Улаанбаатар  
хот

### Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1, 12 дугаар зүйлийн 12.16, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.4 дэх хэсэгт заасныг баримтлан Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Хөхийсүрэнгийн Батсүрэн, Хээмчигийн Сонинбаяр нарыг Улсын Дээд шүүхийн шүүгчийн, Жаргалсайханы Оюунтунгалаг, Чагдаагийн Хосбаяр нарыг Нийслэлийн шүүхийн шүүгчийн, Ванд-Очирын Цэцэнбилэгийг Архангай аймаг дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгчийн, Махайн Ризаг Баян-Өлгий аймгийн Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн, Адъяахүүгийн Сарантуяаг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгчийн, Боролзойн Халиуныг Нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**Ц.ЭЛБЭГДОРЖ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2012 оны 10 дугаар  
сарын 6-ны өдөр

Дугаар 77

Улаанбаатар  
хот

### Улаан буудайн талаар авах зарим арга хэмжээний тухай

Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Тариалангийн тухай хуулийн 15<sup>1.2</sup>-т заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Буудай үйлдвэрлэгч иргэн, хуулийн этгээдэд дотоодын гурилын үйлдвэр болон Тариаланг дэмжих санд нийлүүлсэн стандартын шаардлага хангасан хүнсний улаан буудайн нэг тонн тутамд олгох мөнгөн урамшууллын хэмжээг 100.0 (нэг зуун) мянган төгрөгөөр тогтоож, 2012 оны төсөвт тусгагдаагүй санхүүжилтийг 2013 оны улсын төсөвт тусган, мөн оны I улиралд багтаан олгохыг Сангийн сайд Ч.Улаан, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга нарт даалгасугай.

2. Буудайн нөөц бүрдүүлэх зорилгоор 2011 онд улсын төсвөөс санхүүжүүлсэн 35.0 (гучин таван) тэрбум төгрөгийн зээлийг эргэн төлөх хугацаанд өөрчлөлт оруулан 2013 онд багтаан төсөвт төвлөрүүлэх арга хэмжээ авахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга, Сангийн сайд Ч.Улаан нарт зөвшөөрсүгэй.

3. Улсын Их Хурлын 2008 оны 42 дугаар тогтоолын дагуу Монгол Улсыг хөгжүүлэх санд нөөц хэлбэрээр байршуулсан 80.8 (наян мянга найман зуун) мянган тонн хүнсний буудайн борлуулалт, үүссэн өр, авлагатай холбоотой асуудлыг судалж, холбогдох шийдвэрийн төсөл боловсруулан Засгийн газрын хуралдаанд оруулахыг Монгол Улсын Шадар сайд Д.Тэрбишдагва, Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

4. Тариаланг дэмжих санд хадгалагдаж байгаа хүнсний буудайг гурилын хангамж, үнийг тогтвортой байлгах бодлого, зохицуулалтын хүрээнд дотоодод болон гадаадад зах зээлийн үнээр борлуулах арга хэмжээ авахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулгад даалгасугай.



5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан “Мөнгөн урамшууллын хэмжээ тогтоох тухай” Засгийн газрын 2009 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн 350 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**Н.АЛТАНХУЯГ**

**ҮЙЛДВЭР, ХӨДӨӨ  
АЖ АХУЙН САЙД**

**Х.БАТТУЛГА**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.

Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: [turiin\\_medeel@parliament.mn](mailto:turiin_medeel@parliament.mn)

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас: 0.25

Индекс: 14003